



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор аймаг 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: <a href="mailto:Munkhbatb@audit.gov.mm">Munkhbatb@audit.gov.mm</a></p> <p>Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:TseenyamA@audit.gov.mm">TseenyamA@audit.gov.mm</a></p> <p>Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861 Цахим хаяг: <a href="mailto:Altantuyam@audit.gov.mm">Altantuyam@audit.gov.mm</a></p> <p>Аудитор: Л.Доржханд Утас: 99093683 Цахим хаяг: <a href="mailto:dorjkhandl@audit.gov.mn">dorjkhandl@audit.gov.mn</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Агуулга**

---

2.Аудитын санал дүгнэлт /эх хувь/ .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт .....	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
<b>4.1 Залруулсан алдаа .....</b>	<b>16</b>
4.2 Төлбөрийн акт .....	16
4.3. Албан шаардлага.....	17
4.4. Аудитын зөвлөмж .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19
Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/65

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

Г **БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Л.БҮРНЭЭБААТАР ТАНАА**

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг байгууллагын даргын шийдвэргүйгээр бараа материалын данснаас хассан байна.
- Тайлант онд түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, нийт 2,350.9 мянган төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын

D:\2022-A4 тоот.docx

• 005020645

байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах,” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Бодитой оршин байх”, “Иж бүрэн байх”, “Үнэн зөв байдал”, “Оршин байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>130,548,057.50</b>	<b>110,974,345.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	636,989.50	383,807.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	636,989.50	383,807.00
3351	Байгууллагаас авах авлага	636,989.50	383,807.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	129,911,068.00	110,590,538.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	28,111,830.00	-
35110	Тусгай зориулалттай материал	28,111,830.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	101,799,238.00	110,590,538.00
35410	Бичиг хэргийн материал	3,704,838.00	3,854,838.00
35440	Түлш, шатах тослох материал	300,000.00	300,000.00
35450	Барилгын засварын материал	747,000.00	3,747,000.00
35470	Бусад хангамжийн материал	97,047,400.00	102,688,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,758,417,302.05</b>	<b>2,390,763,315.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,758,417,302.05	2,390,763,315.20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,740,341,677.05	2,372,763,315.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,642,835,047.81	4,684,667,870.81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,167,360,240.62)	(2,513,655,763.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	287,380,500.00	287,380,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(149,479,006.85)	(207,645,530.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	185,994,068.00	199,177,068.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,685,850.19)	(176,029,582.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,933,595.00	97,512,595.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,768,132.12)	(74,053,866.27)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000,000.00	7,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	111,661,520.00	121,701,820.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(43,169,823.98)	(53,291,795.32)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	18,075,625.00	18,000,000.00
39301	Програм хангамж	13,978,000.00	13,978,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,902,375.00)	(13,978,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,888,965,359.55</b>	<b>2,501,737,660.20</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,113,480.96</b>	<b>3,422,544.41</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,113,480.96	3,422,544.41
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,113,480.96	3,422,544.41
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,046,923.55	5,090.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,066,557.41	3,417,454.41
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,886,851,878.59</b>	<b>2,498,315,115.79</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,886,851,878.59	2,498,315,115.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520,400,904.00	520,400,904.00
51101	Өмч: - төрийн	520,400,904.00	520,400,904.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,947,267,868.40	1,558,731,105.60
51210	Өмнөх үеийн үр дүн	1,947,267,868.40	1,947,267,868.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	(388,536,762.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,183,106.19	419,183,106.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,888,965,359.55</b>	<b>2,501,737,660.20</b>

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>574,598,537.50</b>	<b>612,257,391.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>83,222,934.00</b>	<b>60,761,823.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	83,222,934.00	60,761,823.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,222,934.00	316,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	316,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ	00.00	53,186,123.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		7,259,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>491,375,603.50</b>	<b>551,495,568.70</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	70,940,403.50	93,067,868.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,797,648.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,142,755.50	93,067,868.70
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	420,435,200.00	458,427,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,435,200.00	458,427,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>965,313,269.69</b>	<b>1,000,794,154.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>965,313,269.69</b>	<b>1,000,794,154.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	903,627,163.96	922,612,023.95
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	241,868,644.97	244,753,826.00
210101	Үндсэн цалин	241,868,644.97	244,753,826.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,810,381.10	31,693,369.85
210201	Тэтгэврийн даатгал	21,011,667.87	22,379,818.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,459,330.66	2,447,125.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,970,824.53	1,957,700.14
210204	Ажилгүйдлийн даатгал	487,327.36	444,784.67
210205	Эрүүл мэндийн даатгал	4,881,230.68	4,463,940.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,445,980.68	32,644,238.75
210301	Гэрэл, цахилгаан	6,711,480.68	6,994,158.75
210302	Түлш, халаалт	25,734,500.00	25,650,080.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,090,032.45	52,185,156.50
210401	Бичиг хэрэг	5,888,400.00	3,563,950.00
210402	Тээвэр, шатахуун	26,843,062.45	33,017,336.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,129,000.00	937,120.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,980,870.00	4,741,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	248,700.00	9,925,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	349,700.00	00.00
210502	Хоол, хүнс	349,700.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	11,686,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	00.00	11,386,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,944,000.00	7,158,000.00
210702	Дотоод албан томилолт	4,794,000.00	7,158,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	150,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	86,883,084.00	55,304,523.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,098,084.00	52,057,323.00

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	25,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	49,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,485,000.00	2,673,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>466,235,340.76</b>	<b>487,186,509.85</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,699,220.00	53,897,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	433,536,120.76	433,289,109.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,686,105.73</b>	<b>78,182,130.55</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,955,745.00</b>	<b>19,377,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,382,600.00	17,774,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,573,145.00	1,602,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>31,730,360.73</b>	<b>58,805,030.55</b>
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	6,490,093.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,240,267.73	716,494.05
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг-нэмэлт санхүүжилт	00.00	58,805,030.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-390,714,732.19</b>	<b>-388,536,762.80</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>492,375,603.50</b>	<b>551,811,568.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>316,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,000,000.00	316,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,000,000.00	316,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	316,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>491,375,603.50</b>	<b>551,495,568.70</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	70,940,403.50	93,067,868.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,797,648.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,142,755.50	93,067,868.70
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	420,435,200.00	458,427,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	420,435,200.00	458,427,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>492,375,603.50</b>	<b>539,362,568.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>492,375,603.50</b>	<b>539,362,568.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>430,689,497.77</b>	<b>461,200,438.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	229,956,064.66	236,028,899.20
210101	Үндсэн цалин	226,797,364.66	196,361,300.00
210102	Нэмэгдэл	00.00	33,386,699.20
210105	Гэрээт ажлын хөлс	3,158,700.00	6,280,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,369,845.01	31,509,071.00
210201	Тэтгэврийн даатгал	21,194,941.01	22,312,224.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,323,762.00	2,390,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,774,428.00	1,912,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	461,393.00	478,000.00

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210205	Эрүүл мэндийн даатгал	4,615,321.00	4,416,347.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,502,496.15</b>	<b>32,799,365.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,767,996.15	7,640,765.75
210302	Түлш, халаалт	25,734,500.00	25,158,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,723,606.45</b>	<b>49,136,470.00</b>
210401	Бичиг хэрэг	4,331,600.00	3,610,500.00
210402	Тээвэр, шатахуун	21,799,206.45	27,496,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	634,000.00	1,289,570.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	9,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	598,800.00	7,380,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>11,685,100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	00.00	11,385,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,944,000.00</b>	<b>7,258,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,944,000.00	7,258,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>75,653,210.50</b>	<b>35,788,532.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,939,210.50	31,650,332.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	25,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	49,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,540,275.00</b>	<b>56,995,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,540,275.00	56,995,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,686,105.73</b>	<b>78,162,130.55</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,955,745.00</b>	<b>19,357,100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,382,600.00	17,774,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,573,145.00	1,582,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>31,730,360.73</b>	<b>58,805,030.55</b>
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	6,490,093.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,240,267.73	716,494.05
213404	Хөрөнгийн	00.00	58,088,536.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>12,449,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>12,449,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>12,449,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>12,449,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	12,449,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-12,449,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

7



**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	520,400,904.00	450,946,187.28	2,433,553,596.07	3,404,900,687.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	31,763,081.09	31,763,081.09
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>520,400,904.00</b>	<b>450,946,187.28</b>	<b>2,465,316,677.16</b>	3,436,663,768.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-127,890,017.36	-127,890,017.36
C08	<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>520,400,904.00</b>	<b>419,183,106.19</b>	<b>1,947,267,868.40</b>	2,886,851,878.59
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>520,400,904.00</b>	<b>419,183,106.19</b>	<b>1,947,267,868.40</b>	2,886,851,878.59
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>520,400,904.00</b>	<b>419,183,106.19</b>	<b>1,947,267,868.40</b>	2,886,851,878.59
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-388,536,762.80	-388,536,762.80
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>520,400,904.00</b>	<b>419,183,106.19</b>	<b>1,558,731,105.60</b>	2,498,315,115.79

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	459,427,700.00	458,027,205.95	1,400,494.05	99.70
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	459,427,700.00	458,027,205.95	1,400,494.05	99.70
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	440,053,100.00	438,670,105.95	1,382,994.05	99.69
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	236,028,900.00	236,028,899.20	0.80	100.00
210101	Үндсэн цалин	196,372,720.20	196,361,300.00	11,420.20	99.99
210102	Нэмэгдэл	33,375,279.80	33,386,699.20	(11,419.40)	100.03
210105	Гэрээт ажлын хөлс	6,280,900.00	6,280,900.00	-	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,268,900.00	31,509,071.00	759,829.00	97.65
210201	Тэтгэврийн даатгал	22,707,800.00	22,312,224.00	395,576.00	98.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,390,300.00	2,390,300.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,912,200.00	1,912,200.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	478,000.00	478,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,780,600.00	4,416,347.00	364,253.00	92.38
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,403,900.00	32,799,365.75	604,534.25	98.19
210301	Гэрэл, цахилгаан	8,245,300.00	7,640,765.75	604,534.25	92.67
210302	Түлш, халаалт	25,158,600.00	25,158,600.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,357,200.00	50,356,470.00	730.00	100.00

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210401	Бичиг хэрэг	3,610,500.00	3,610,500.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	27,496,400.00	27,496,400.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,290,300.00	1,289,570.00	730.00	99.94
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,360,000.00	9,360,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,600,000.00	8,600,000.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,685,100.00</b>	<b>16,685,100.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	11,385,100.00	11,385,100.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,658,100.00</b>	<b>7,258,000.00</b>	<b>400,100.00</b>	<b>94.78</b>
210702	Дотоод албан томилолт	7,658,100.00	7,258,000.00	400,100.00	94.78
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,051,000.00</b>	<b>7,038,200.00</b>	<b>12,800.00</b>	<b>99.82</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,900,000.00	2,900,000.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,000.00	25,000.00	2,000.00	92.59
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	49,200.00	10,800.00	82.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	-	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>566,000.00</b>	<b>569,950.00</b>	<b>(395,000.00)</b>	<b>100.70</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,600,000.00	56,995,000.00	(395,000.00)	100.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>193,746,000.00</b>	<b>193,571,000.00</b>	<b>17,500.00</b>	<b>99.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,374,600.00</b>	<b>19,357,100.00</b>	<b>17,500.00</b>	<b>99.91</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,774,600.00	17,774,600.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,582,500.00	17,500.00	98.91
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>459,427,700.00</b>	<b>458,027,205.95</b>	<b>1,400,494.05</b>	<b>99.70</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>458,427,700.00</b>	<b>457,711,205.95</b>	<b>716,494.05</b>	<b>99.84</b>
132001	Орон нутгийн төсвөөс	458,427,700.00	457,711,205.95	716,494.05	99.84
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>316,000.00</b>	<b>684,000.00</b>	<b>31.60</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	316,000.00	684,000.00	31.60
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>22</b>	<b>1</b>	<b>95.65</b>
620001	Удирдах ажилтан	9	9	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10	9	1	90.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0	100.00
620004	Гэрээт ажилтан	1	1	0	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>22</b>	<b>1</b>	<b>95.65</b>

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7	6	1	85.71
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	0	100.00
650010	Гэрээт ажилтан	2	2	0	100
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	0	100

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021.12.31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>64,450,310.5</b>	34,979,332.20
131103	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,307,555.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,142,755.5	34,979,332.20

**3. Аудитын тайлан**

**3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 2/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## **Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулахдаа нэгдүгээр гарын үсгийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бүрнээбаатар, нягтлан бодогч Г.Ууганзаяа хоёрдугаар гарын үсгийг зурсан байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Бууцагаан сумын ЗДТГ нь нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд төр, нийгмийн үйлчилгээг үзүүлэх, сумын хэмжээнд төрийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын зорилго зорилт нь: Орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологийг ажил албандаа нэвтрүүлж өндөр боловсрол мэргэжилтэй чадварлаг төрийн албаны бүтцээр төрийн үйлчилгээг байгууллага иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын даргын 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/07 дугаартай тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталсан нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь аймгийн ТЕЗ-ийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 965,313.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,653.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 6,274.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,505.2 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 387,227.7 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	130,548.1	110,974.3	(19,573.7)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	637.0	383.8	(253.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	129,911.1	110,590.5	(19,320.5)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,758,417.3	2,390,763.3	(367,654.0)
Үндсэн хөрөнгө	5,363,782.7	5,429,417.9	65,635.1
Хуримтлагдсан элэгдэл	(2,605,365.4)	(3,038,654.5)	(433,289.1)
<b>Нийт хөрөнгө</b>	2,888,965.4	2,501,737.7	(387,227.7)
Өр төлбөр	2,113.5	3,422.5	1,309.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,886,851.9	2,498,315.1	(388,536.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	2,888,965.4	2,501,737.7	(387,227.7)

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл 383.8 мянган төгрөг болж 253.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлага бүрэн барагдаж, гэрэл цахилгааны төлбөрийг төрийн сан давхар гүйлгээ хийсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 110590.5 мянган төгрөг болж 19320.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 93,577.4 мянга, аймгийн Онцгой байдлын газраас үнэ төлбөргүй олгосон материал 4,150.0 мянга, “Баялаг-говь” ХХК-аас үнэ төлбөргүй олгосон материал 3,109.7 мянга нийт 7,259.7 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн бөгөөд 120,157.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,429,417.9 мянган төгрөг болж 65,635.1 мянган төгрөгөөр өссөн нь “Баялаг-говь” ХХК-аас үнэ төлбөргүй олгосон 6,590.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ОНХС-аар 41,832.8 мянган төгрөгийн 2 ширхэг худаг, аймгийн Мал эмнэлгийн газраас олгосон 4,763,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 12,449.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна.

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Өмнөх оны цалингийн зардалтай холбоотой 1,046.9 мянган төгрөгийн өрийг барагдуулж, тайлант онд түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, өмнөх оны бусад зардлын тооцооны өглөг 1,066.6 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,498,315.1 мянган төгрөг болж 388,536.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 388,536.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 465,501.8 мянган төгрөгөөр, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 58,968.7 мянган төгрөгөөр бууруулж 406,533.7 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт 1 удаа өөрчлөлт хийж 2021 оны 8 дугаар сард 459,427.7 мянган төгрөгөөр тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 458,427.7 мянга, өөрийн орлогоос 1,000.0 мянган нийт 459,427.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 458,427.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 457,711.2 мянган төгрөгийг зарцуулж 716,4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 458,027.2 мянган төгрөг буюу 99.7 % хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 604,5 мянга, хангамж бараа материалын зардал 0.7 төгрөг, томилолтын зардал 5.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 12.8 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 17.5 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 7,269.9 мянга, иргэд сумын Онцгой комисст олгосон хандив 7,772.0 мянга, түрээсийн орлогоос 4,370.0 мянга, төрөөс хариуцсан ундны усны төлбөр 7,850.7 мянга, хог хаягдлын хураамж 396.0 мянга, өмнөх оны татан төвлөрүүлэлт 6,490.0 мянга, мал тооллогын зардал 1,071.0 мянга, газрын нөхөн сэргээлт болон газрын төлбөр 686.8 мянга, мал ариутгалын хөлс 220.4 Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

мянга хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянга, аймгийн ОНХС-аас 29,850.0 мянга, аймгийн замын сангаас 27,000.0 мянган төгрөг нийт 93,067.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 34,979.3 мянган төгрөгийг зарцуулж, 58,088.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 89 ажил арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 85 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бууцагаан сумын ИТХ-ын хуралдааны 2018.10.03-ны өдрийн “Өвс тэжээлийн үнэ чөлөөлөх тухай” 03 дугаар тогтоолын дагуу санхүүгийн тайлангийн бараа материалын тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй 28,111.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнээс 7,500.0 мянган төгрөгийг чөлөөлсөн байна.

Мөн дансны үлдэгдэл болох 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийг үнийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн боловч байгууллагын даргын шийдвэргүйгээр данс бүртгэлээс хассан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 1,000,794.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 35,480.8 мянган төгрөгөөр буюу 3,6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, нормативд зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Бууцагаан сумын ЗДТГ нь 2021 онд 614,428.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 549,051.0 мянган төгрөгийн 143 мэдээллийг хугацаандаа байршуулж 65,377.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

**Хүснэгт 2. Шилэн дансны мэдээлэл**

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	32	4	
5	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	141	8	2

Эх сурвалж: Шилэн дансны нэгдсэн системээс

**3.9.2 ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ "ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" 43 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

Тайлант онд 459,427.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 458,027.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал болох 171,755.3 мянган төгрөгөөс 10 хувь болох 17,175.5 мянган төгрөг хэмнэхээс 796.0 мянган төгрөгийг хэмнэж 16,379.5 мянган төгрөгийг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

Мөн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 33,403.9 мянган төгрөгөөр баталж 32,799.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 6,680.7 мянган төгрөг хэмнэхээс 604.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган 6,076.2 мянган төгрөг хэмнээгүй нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8 дахь заалттай нийцэхгүй байна.

**3.9.3 БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

**3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 57,252.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 2,003.2 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 55,249.3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Дээрх алдаа зөрчлийн барагдуулж хэрэгжилтийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021.06.25-ны өдрийн 68 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд 1,620.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг байгууллагын даргын шийдвэргүйгээр зарлагдсан байна. Уг асуудлаар аймгийн Цагдаагийн газарт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байгаа болно.

Иймд өвс тэжээлийн орлого, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 95,993.3 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 115.0 мянган төгрөгийн 1 алдаанд төлбөрийн акт, 21,678.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, завсрын аудитаар илэрсэн 1 зөрчилд албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх 74,199.9 мянган төгрөгийн 5 алдаанд зөвлөмж хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

1.Тайлант оны санхүүгийн тайлангаар бусад хангамжийн материалын дансны эхний болон эцсийн үлдэгдлийг Сангийн яамны Э-тайланд аж ахуйн материал 35420 дансанд зөрүүлж шивсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", санхүүгийн тайлангийн "Ангилал", "Оршин байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сангийн яамны Э-тайланд үлдэгдлийг залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

1.Тус сумын Соёл амралтын хүрээлэнгийн автомат худгийг харж хамгаалах, ногоон байгууламжийг усалж ургуулах, эвдэрсэн хашаа, хамгаалалтыг засаж сэлбэх ажлыг гүйцэтгэхээр П.Батаатай 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот гэрээг 2 жилээр байгуулж 950000 төгрөг олгосон байхад цалингаас татварыг суутган тооцоогүй.

2.Байгууллагын даргын 2021 оны Б/08, Б/18 дугаар тушаалуудаар шинээр хүүхэдтэй болсон 2 ажилтанд олгосон тус бүр нь 100.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламжаас ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого, 7.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого, 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна", санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал, үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын гэрээт ажилтны цалингаас дутуу суутгасан ХХОАТ-ын 95,000 төгрөгийг П.Батаагаар, олгосон тэтгэмжээс дутуу суутгасан 10,000 төгрөгийг Ж.Доржгочоо, Х.Нарангэрэл нараас тус тус суутган авч орон нутгийн төсөвт төлүүлэхээр төлбөрийг акт тогтоов.

#### 4.3. Албан шаардлага

1. Тус байгууллага хөрөнгө, аж ахуйн материалын тайланг 2021 оны 9 сарын байдлаар гаргаагүй, байгууллагын даргын 2021 оны А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан тооллогын комисс хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийсэн боловч хөрөнгийг тооцоо бодсон актаар баталгаажуулж, үр дүнг тооцоогүй байна.

Энэхүү зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1. "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ", 70 дугаар зүйлийн 70.2.2. "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/,", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын 2021 оны үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тайланг нөхөн гаргуулж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодсон актаар баталгаажуулах арга хэмжээ авч ажиллах.

#### 4.4. Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### ***Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

1. Санхүүгийн тайлангийн бараа материалын тусгай зориулалтын дансанд бүртгэлтэй 20,611.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнийг байгууллагын даргын шийдвэргүйгээр бараа материалын данснаас хассан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", санхүүгийн тайлангийн "бодитой оршин байх", "Эрх ба үүрэг" Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын даргын шийдвэргүйгээр зарлагдсан 20,611.8 мянган төгрөгийн өвс, тэжээлийг бараа материалын дансанд буцаан орлого авах. Цаашид анхан шатны баримтгүй, холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр хөрөнгийн зарлага гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах.

2. Сумын Төрийн сангийн мэргэжилтэн 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хийсэн 395.0 мянган төгрөгийн гүйлгээ нэр данс зөрүүтэй байснаас буцаж орсоныг бараа үйлчилгээний зардлаар бүртгэлгүй, томилолтын зардлаар хааснаас төсвийн гүйцэтгэлийн тайланд дээрх 395.0 мянган төгрөгөөр зардал хооронд зөрүү үүсэж тайлан буруу илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Аудитын код **БНА-2022/40/НА-СТА-ТШЗ**

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Байгууллагын дарга, нягтлан бодогч нар холбогдох анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийхээс өмнө хянан баталгаажуулж, Төрийн сан холбогдох гүйлгээний зардлын эдийн засгийн ангилал дээр тавих хяналтыг сайжруулах.

3. Тус байгууллага нь 2021 онд 614,428.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 549,051.0 мянган төгрөгийн 143 мэдээллийг хугацаандаа байршуулж 65,377.8 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх.

4.1. Тайлант онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 33,403.9 мянган төгрөгөөр баталж 32,799.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 6,680.7 мянган төгрөг хэмнэхээс 604,5 мянган төгрөгийг хэмнэж 6,076.2 мянган төгрөг хэмнээгүй.

4.2. Мөн түлш, халаалтын 491.5 мянга, тээвэр шатахууны өглөг 1,351.9 мянга, үзэсгэлэнт Баянхонгор төслийн хүрээнд хийгдсэн видео контент, бичлэгийн ажлын хөлс 507.6 мянга, нийт 2,350.9 мянган төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид байгууллагын удирдлага төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өглөгийн эзэн холбогдогчийг тогтоож, авлага, өглөгийг бүрэн барагдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлэх гэсэн зөвлөмж өгсөн боловч 1,066.5 мянган төгрөгийн өглөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.”төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, санхүүгийн тайлангийн “бодитой оршин байх”, “Эрх ба үүрэг” Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан 1,066.5 мянган төгрөгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрийг гаргуулан 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнд хааж залруулах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

**Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян. төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
1	ТШЗ	7	24,539.3	1		1	115.0	1		3	22,073.4
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>24,539.3</b>	<b>1</b>		<b>1</b>	<b>115.0</b>	<b>1</b>		<b>3</b>	<b>22,073.4</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
1	Шилэн данс	1	65,377.8							1	65,377.8
2	ЗГ-ын 43 дугаар тогтоол	1	6,076.2							2	8,427.1
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>71,454.0</b>							<b>3</b>	<b>73,804.9</b>
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>9</b>	<b>95,993.3</b>	<b>1</b>		<b>1</b>	<b>115.0</b>	<b>1</b>		<b>6</b>	<b>95,878.3</b>

оОо



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 08/A0570643  
БНА-2022/40/НА-СТА-ТШЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус байгууллага хөрөнгө, аж ахуйн материалын тайланг 2021 оны 9 сарын байдлаар гаргаагүй.
2. Байгууллагын даргын 2021 оны А/19 дүгээр тушаалаар байгуулагдсан тооллогын комисс хөрөнгийн эхний хагас жилийн тооллого хийсэн боловч хөрөнгийг тооцоо бодсон актаар баталгаажуулж, үр дүнг тооцоогүй байна.

Энэхүү зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1. "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ", 70 дугаар зүйлийн 70.2.2. "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2- т "

Alban bichig 2022 албан шаардлага

005040482


Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй.” гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын 2021 оны үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тайланг нөхөн гаргуулж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийж тооцоо бодсон актаар баталгаажуулах арга хэмжээ авч ажиллах.

2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бүрнээбаатар, нягтлан бодогч Г.Ууганзаяа нарт хариуцуулав<sup>2</sup>.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН <sup>3</sup>:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ  
АУДИТОР П.ДОРЖХАНД



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 08/A0570643  
БНА-2022/40/НА-СТА-ТШЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус сумын Соёл амралтын хүрээлэнгийн автомат худгийг харж хамгаалах, ногоон байгууламжийг усалж ургуулах, эвдэрсэн хашаа, хамгаалалтыг засаж сэлбэх ажлыг гүйцэтгэхээр П.Батаатай 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 02 тоот гэрээг 2 жилээр байгуулж 950000 төгрөг олгосон байхад цалингаас татварыг суутган тооцоогүй.
2. Байгууллагын даргын 2021 оны Б/08, Б/18 дугаар тушаалуудаар Нийгмийн даатгалын байцаагч ажилтай Ж.Доржгочоо, Ус цаг уурын харуул ажилтай Х.Нарангэрэл нарт шинээр хүүхэдтэй болсон тул тэтгэмж урамшууллын зардлаас тус бүр 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон боловч ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого, 7.1.2.ажил олгогчоос ажилтан, түүний гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого, 21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм

Alban bichig Акт-2021

005050243

хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.4 дэх “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Байгууллагын гэрээт ажилтны цалингаас дутуу суутгасан ХХОАТ-ын 95,000 төгрөгийг П.Батаагаар, олгосон тэтгэмжээс дутуу суутгасан 10,000 төгрөгийг Ж.Доржгочоо, Х.Нарангэрэл нараар тус тус төлүүлж Бууцагаан сумын Бх.Бу хувь хүнээс суутгасан орлогын албан татварын 100030400910 тоот дансанд төвлөрүүлэх.

Актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор багтаан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг<sup>1</sup>, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бүрнээбаатар, нягтлан бодогч Г.Ууганзаяа нарт хариуцуулав<sup>2</sup>.

### **ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

А.ЦЭЭНЯМ  
Л.ДОРЖХАНД

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно